



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 08 сарын 16 өдөр

Дугаар 1/66

Улаанбаатар хот

Г Зочид буудал, дэн буудал, амралтын
газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл
олгох, цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, газрын дүрмийн 2.5.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.
2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.
3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Чингис хаан цогцолбор ХХК-ний "Чингис хаан" зочид буудлын 13/12, Оюуны аав ХХК-ний "Агора" зочид буудлын 14/47, Иргэн С.Пүрэвдоржийн "Баянбүрд" дэн буудлын 15/003, МҮЭХ-ны харьяа YYT-ийн "Альфа" зочид буудлын 16/055, Билэгт учрал ХХК-ний "Билэгт учрал" дэн буудлын 16/021 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.
4. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг байгууллага болон иргэн тус бүрээс хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-т даалгасугай.
5. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэд нь гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтсийн дарга /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /Б.Отгонсувд/-д үүрэг болгосугай.

ДАРГА

D.Batsoy Д.БАТСҮХ



Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2017 оны 08 сарын 16 өдрийн ~~16~~ дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2017.08.16

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Чингис хаан цогцолбор ХХК	2095238	Чингис хаан	БЗД-ийн 1-р хороо Токиогийн гудамж-10
2	Оюуны аав ХХК	5299691	Агора	БЗД-ийн 16-р хороо Улаанхуарангийн гудамж-80
3	МҮЭХ-ны харъяа YYT	1067273	Альфа	ЧД-ийн 2-р хороо Чоймболын гудамж 4-1

-ооОоо-

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2017 оны 08 сарын 16
өдрийн 466 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

1117139265
УОА0453 5284325

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2017.08.16

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Иргэн Б.Санжав	УО68090535	Говь-2	БЗД-ийн 8-р хороо Хилчний гудамж Бөхөд ХХК-ны байр
2	Иргэн С.Пүрэвдорж	ЙЭ71081973	Баянбүрд	ЧД-ийн 6-р хороо Баянбүрд цогцолбор
3	Билэгт учрал ХХК	5264103	Билэгт учрал	СХД-ийн 2-р хороо 21-368

-ооОоо-